

Монгол дахь оюутан залуучуудын үнэт зүйлсийн төлөвшил, онцлог

Монхоорой Батбаатар 

Дэд профессор, Монгол Улсын Их Сургууль. Социологи, нийгмийн ажлын тэнхим,
Улаанбаатар, Монгол Улс

Хүлээн авсан - Received:
2025-04-04

Засварласан - Revised:
2025-05-19

Хэвлэгдсэн - Published:
2025-06-10

mbatbaatar@num.edu.mn

ORCID: [0000-0001-5308-324X](https://orcid.org/0000-0001-5308-324X)



© 2025, Author(s)

Хураангуй: Тус өгүүлэлд Монгол Улсын хүн амын суурь бүлэг болох оюутан залууст тулгамдаж буй асуудал, үнэт зүйлсийн төлөвшил, онцлогийг харьцуулан авч үзсэний үндсэн дээр өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлсон болно.

Нийтээр аж төрөх ёс, бүх нийтийн өмч, хамтын хөдөлмөр, нийгмийн сахилга дэг журмыг эрхэмлэж ирсэн социалист тогтолцооноос ардчилсан, зах зээлийн нийгэмд шилжсэнээр хүмүүсийн үнэт зүйл, эрхэмнэлийн тогтолцоо өөрчлөгдсөн. Социализмын дараах нээлттэй, зах зээлийн нийгэмд амьдарч залуучуудын үнэт зүйл, эрхэмнэл үлэмж өөрчлөгдөж байна. Оюутнуудын дунд явуулсан үнэт зүйлийн судалгаагаар нэгд хүмүүжил, ёс суртахуун (21.5%), хоёрт эрдэм боловсрол (18.6%), гуравт эх орон (10.8%), дөрөвт эрх чөлөө (10.3%), тавд мөнгө (8.9%)-ийг эрхэмлэн дээдлэж явдгаа илэрхийлжээ.

Энэхүү өгүүлэлд Монгол Улсын өнцөг булан бүрээс нийслэл хотод суралцаж буй 5638 оюутан залуучуудыг санамсаргүй түүврийн аргыг хамруулан судалж, гол үр дүнг хураангуйлан хүргэж байна.

Түлхүүр үг: Нийгэм-хүн ам зүйн бүлэг, амьдралын хэв маяг, тулгамдаж буй асуудал, үнэт зүйл, эрэмбэ

1. ОРШИЛ

Монгол Улс бол оюутан залуучуудын орон бөгөөд нийгмийн хөгжлийн тулгуур болсон энэхүү бүлгийн хэрэгцээ, сонирхол, хөгжил, хандлага, асуудал бэрхшээлийн талаар Залуучуудын хөгжлийн хэрэгцээ, нийгмийн тулгамдаж буй асуудлыг тодорхойлох суурь судалгаа хийж (МЗХ, Полиси төв, 2003), хүн амын тухайн бүлэгт чиглэсэн үндэсний хөтөлбөр (МУЗГ, Өсвөр үе, залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр, 2006) хэрэгжүүлж ирсэн байна. Тухайлбал, Монголын Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг 1998-2005 онуудад 2 үе шаттайгаар хэрэгжүүлсний зэрэгцээ Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого зэрэг бусад бодлого, чиглэлд залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээг тусган хэрэгжүүлж ирсэн (МУЗГ, Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, 2004).

Монгол Улсын нийт хүн амын дотор 30 хүртэлх насны залуучууд 1980-аад онд 70 гаруй хувьтай байсан бол 1990 онд 72.8 хувийг эзэлж “оргил үе” тохиож байв. Үүнээс хойш хүн амын төрөлт буурч, насжилтын нөлөөгөөр залуу үеийн хувийн жин нэмэгдэхгүй, аажмаар буурч эхэлж байна. Одоогийн байдлаар Монгол Улсын нийт хүн амын 63.77 хувийг 35 хүртэлх насны залуучууд эзэлж байгаа бөгөөд үүнээс 15-19 насныхан 230 орчим мянга, 20-24 насны залуус 245 мянга орчим байгаа бөгөөд нийт хүн амын 14.6 хувийг эзэлж байна (Үндэсний статистикийн хороо, 2024). Мөн дээд боловсролын сургалтын 94 байгууллагад 200 гаруй мянган залуучууд суралцаж байна. Их дээд сургууль, коллежид суралцагчдын хүйсийн харьцааг авч үзэхэд сүүлийн жилүүдэд сүүлийн 20 жилийн байдлаар эмэгтэйчүүдийн тоо тасралтгүй өсөж, 2021 оны байдлаар 74.3%-д хүрчээ (Үндэсний статистикийн хороо, 2019).

Эдүгээ оюутан залуучуудын талаар баримтлах төрийн бодлого тодорхой болж, Монгол Улсын Их хурлаас 2017 оны 05 сарын 18-ны өдөр Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг баталж,

2018 оны 1 дүгээр 01-ний өдрөөс тус хууль хэрэгжиж эхэлсэн (УИХ, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, 2017). Өнгөрсөн хугацаанд залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай болсноор Залуучуудын хөгжлийг дэмжих эрх зүйн үндэс суурь бий болж, нийгмийн хөгжилд оролцох оюутнуудын оролцоо, эрх үүргийг тодорхойлохтой холбоотой дүрэм, журамтай болох ажил эрчимтэйгээр хэрэгжих үндэс суурь баттай тавигдсан юм. Ингэснээр оюутан залуучууд ямар нөхцөлд, хэрхэн амьдарч, юуг хүсэн мөрөөдөж, үнэлж, хэрхэн төлөвшиж, хөгжиж байна, тэдэнд юу хэрэгтэй, хэрхэн өөрчлөгдөж байгаа талаар сонирхон судлах эхлэл тавигдаж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, бодлогод тусгах, үйлчилгээ үзүүлэх чиглэлд ахиц дэвшил гарч байна.

2.Сэдвийн судлагдсан байдлын тойм

Тухайн сэдвээр үндэсний болон олон улсын түвшинд хийсэн цөөнгүй судалгаа бий. “Залуучууд” хэмээх ойлголтыг суурь судалгаанд “Насны шинж байдал, нийгмийн байр суурийн онцлог зэрэг нийгмийн байгууламж, соёл, нийгэмшлийн зүй тогтол, хүмүүжлийн онцлогоос улбаалан нийгэм-сэтгэл зүйн шинж байдлаар нөхцөлдсөн цогц байдлаар адилтгаж тодорхойлогддог нийгэм-хүн ам зүйн бүлэг” хэмээсэн байдаг (ШУТС-ийн төслийн тайлан, 2018). Залуучууд судлалд тэдний нас (хүүхэд, идэрчүүд), үйл ажиллагаа (суралцагч, ажилчин), оршин суугаа газар (хот, аймаг) зэргээрээ өөр өөр байдаг, нөгөө талаас залуучууд нийгэм, хүн ам зүйн шинжээрээ буюу нас, хүйс, боловсрол, оршин суугаа нутаг дэвсгэрээсээ хамаарч тэдний ухамсар, ашиг сонирхол, үнэт зүйлийн хувьд харилцан адилгүй байдаг. НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд (UN, <http://www.un.org/en/events/youthday/sg.shtml>, 2024), Дэлхийн банк, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, залуучуудын бүлэгт 16-29 хүртэлх насны залуусыг багтааж үздэг. 15-24 насны залуучуудын нийгэм, сэтгэлзүйн байдал нь өвөрмөц онцлогтой байх бөгөөд эрдэмтдийн судалсанаар өсвөр нас буюу 12-20 хүртэлх насанд хүүхдүүд өөрсдийгөө таньж мэдэх, өөрийн дотоод ертөнцийг хүлээн зөвшөөрөх хэрэгцээ ихээхэн өндөр байдаг ажээ. Тухайн орны залуучууд улс орны нийгэм, эдийн засгийн гол хөшүүрэг төдийгүй материаллаг болон оюуны соёлын идэвхтэй субъект, өвлөгч бөгөөд тээн явагч байдаг. Энэхүү өгүүлэлд авч үзэж буй оюутан залуучууд бол 19-24 хүртэлх насны, мэргэжил эзэмшихээр суралцаж буй бүлэг болно.

Монголын залуучуудын хэрэгцээ, сонирхол сэдвээр 2003 онд Полиси төвөөс эрхлэн явуулсан судалгаанд Залуучуудын суурь хэрэгцээг тодорхойлсон боловч оюутнуудын үнэт зүйлийг судлаагүй байна. (МЗХ, Полиси төв, 2003) Монголчуудын үнэт зүйлс нэртэй суурь судалгааг 2019 онд СУИС-аас эрхлэн явуулсан (СУИС, 2019) бөгөөд энэхүү судалгаанд иргэдийг хамруулан дүгнэлт хийсэн боловч, оюутнуудыг хамруулаагүй, тухайн бүлгийн үнэт зүйл, эрхэмнэлийг тодорхойлоогүй байна. Харин 2023 онд судлаач А.Сүхээ (Sukhee.A, 2023) оюутны үнэт зүйл суралцагчийн мэргэжлийн хандлагатай хэрхэн холбогдохыг судалсан ба энэхүү судалгаа нь түүврийн тоо хэмжээний хувьд явцуу хүрээнд хийгдсэн, зөвхөн сэтгүүлч мэргэжлээр суралцагчдын бие хүний үнэт зүйл ба мэргэжлийн хандлага хоорондын уялдаа холбоог авч судалсан байна.

Шинэ мянганы босгон дахь залуучууд, тэр дундаа мэдээлэл технологи асар хурдацтай хөгжиж буй өнөө цагт цахим болон нийгмийн сүлжээний нөлөөгөөр олон талт харилцаа, шинэчлэлт өөрчлөлтийг чухалчилсан үнэт зүйлтэй, өвөрмөц бөгөөд онцлог хэрэгцээ, хэрэглээ бүхий нэн шинэ үе бүрэлдэн бий болж байна. Дээрх нөхцөл байдалд тулгуурлан төрийн их сургуульд суралцаж буй оюутан залуусын нийгмийн үйл ажиллагаа, амьдралын хэв маяг, сургалт, хүмүүжил, соёл харилцаа, хөгжлийн үйл явцыг чиглүүлэгч болж байдаг үнэт зүйлсийн баримжаалал хэрхэн бүрэлдэж буйг судлан тодорхойлохын тулд энэхүү суурь судалгааг хийсэн (Социологийн Боловсрол төв, 2023) юм.

3.Судалгааны арга зүй

Оюутан залуучуудаас мэдээлэл цуглуулахад асуумж, ярилцлагыг үндсэн арга болгосны зэрэгцээ баримт бичгийн судалгааны аргыг ашиглан мэдээлэл цуглуулсан. Анкетын аргаар цуглуулсан мэдээлэлд боловсруулалт хийх программ “SPSS-27.0”-ыг хэрэглэн боловсруулсан юм. Цуглуулсан мэдээлэлд анхдагч үр дүн болох нэг хэмжээст тархалтыг тооцохын зэрэгцээ, шинээр хувьсагч үүсгэх, логик ангилал гаргах, харьцуулалт болон мэдээлэл боловсруулалтыг статистик шинжилгээ ашиглан хийж, нэгтгэн дүгнэсэн болно.

4. Судалгааны үр дүн. хэлэлцүүлэг

Судалгаанд хамрагдсан оюутан залуучуудын насны ангилалыг 18 хүртэлх насны, 19-20 хүртэлх, 21-24 хүртэлх, 25-аас дээш насны гэсэн дөрвөн бүлэгт хувааж үзсэн. Судалгаанд хамрагдсан оюутнуудын 11.5% нь 18 хүртэлх насны, 46.1% нь 19-20 хүртэлх насны, 36.1% нь 21-24 хүртэлх насны залуус байсан юм. Харин 25 ба түүнээс дээш настай оюутнууд 6.3%-ийг бүрдүүлж байлаа. Судалгаанд хамрагдсан оюутнуудын хүйсийн байдлыг харьцуулан авч үзэхэд оюутнуудын 29.1% буюу 1641 нь эрэгтэй, 70.3% буюу 3961 нь эмэгтэй байв. Харин өөрсдийгөө аль нэг хүйст оруулахаас татгалзсан буюу бусад гэсэн хариултыг 0.6% буюу 36 оюутан залуучууд байна.

Оюутан залуусын өмнө тулгамдаж буй асуудал ба үнэт зүйлсийн төлөвшил. Дэлхийн улс орнууд залуу хүний амь нас, эрүүл мэнд, бие бялдарт тулгамдаж асуудлыг тодорхойлж, сайн сайхан байдлыг хангах нийгмийн хүчин зүйлсийг судлан тодорхойлоход анхаарч байна. Ялангуяа энд авч үзэж буй оюутнууд залуучуудын бүлэгт багтаж буй суурь бөгөөд өвөрмөц бүлэг болохын хувиар олон тооны асуудлуудтай нүүр тулж байна. Тухайлбал, оюутан залуусын өмнө хүчирхийлэл, гадуурхал, архи тамхи, согтууруулах ундааны хэрэглээ, гэмт хэрэг, хүсээгүй жирэмслэлт, сурлагын амжилт, шинийг эрж хайсан үнэт зүйлээс үүссэн хүндрэл бэрхшээлээс үүдэлтэй сэтгэлзүйн хийгээд нийгмийн дасан зохицохуйн олон тооны асуудал тулгамдсан хэвээр байна. Оюутан залуучуудын өмнө тулгамдаж буй асуудал, хүндрэл бэрхшээлийн цөөнгүй хэсэг нь тэдний суурь ур чадвар болон үнэт зүйлийн төлөвшилтэй их бага хэмжээгээр хамааралтай. Оюутнуудын үзсэнээр тэдний санааг зовоож буй тулгамдаж буй асуудлын нэгт ирээдүйн баталгааны тухай асуудал-51.7% хичээл сурлагын асуудал-48.7%, мөнгө, санхүүгийн асуудал-46.0%, үнийн өсөлт-20.6%-иар тэргүүлж байна.

Хүснэгт-1. Оюутнуудын санааг зовоож буй асуудлууд

		Санаа маш их зовдог	Бага зэрэг санаа зовдог	Санаа зовдоггүй
1	Ирээдүйн баталгааны тухай асуудал	51.7	38.7	9.6
2	Хичээл сурлагын асуудал	48.7	41.4	9.9
3	Мөнгө, санхүүгийн асуудал	46.3	44.7	9.0
4	Ажилд орох тухай асуудал	41.6	42.6	15.8
5	Улс төр, нийгмийн асуудал	36.0	49.4	14.6
6	Эрүүл мэндийн асуудал	35.8	49.3	14.8
7	Бие бялдарын асуудал	34.5	48.5	17.0
8	Хувийн зан ааш, сэтгэл санааны байдал	34.2	48.0	17.8
9	Гоо сайхны асуудал	33.2	48.6	18.2
10	Гэр бүлийн харилцааны асуудал	20.7	42.7	36.7
11	Найз нөхдийн харилцааны асуудал	14.5	44.9	40.6

Эдгээр асуудлын зэрэгцээ улс төр, нийгмийн асуудал-36.0%, эрүүл мэндийн асуудал-35.8%, бие бялдарын асуудал-34.5% зэрэгт санаа зовох байдал гарч байна. Оюутнуудын санааг зовоож буй дээрх асуудлыг шийдвэрлэхэд чухам хэнд ханддаг талаар тодруулсан. Уламжлалт хандлагаар авч үзэхэд хүүхэд залууст ямар нэг асуудал үүсэхэд аав, ээждээ ханддаг байсан нөхцөл байдал ихээхэн өөрчлөгджээ. Судалгаанд хамрагдсан оюутнуудын хувьд өөрт тулгамдаж буй асуудлаа дотны найз-22.2% эсвэл ээжтэйгээ-21.8% хуваалцдаг буюу хуваалцахад бэлэн байна. Түүнчлэн хэнтэй ч биш дотроо хадгалахыг хичээдэг-12.8% дараагийн өндөр тохиолдол бөгөөд энэ нь нэг талаас ганцаардал бий болгох, нөгөө талаас сэтгэл гутралыг харуулах нэгэн үзүүлэлт юм.

Оюутан залуучуудын үнэт зүйлсийн төлөвшил. Залуучуудад үнэт зүйлсийн ямар суурь бүрэлдэн бий болж байгаагаас ирээдүйн нийгмийн байдал ихээхэн хамаарна. “Нийгмийн шилжилтийн үеийн үнэт зүйлсийн баримжааллын өөрчлөлт” судалгаандаа Гаврилюк, Трикоз нар (Гаврилюк.В, Трикоз.Н, 2002) “залуучуудын үнэт зүйлсийн баримжааллыг судлах нь нийгмийн

шинэ нөхцөл байдалд дасан зохицох түвшин, түүний нөөц боломжийг тодорхойлох үндэс болдог” гэжээ.

Судлаачдын тэмдэглэснээр (Skelton.A, 1997) оюутны сурах хандлагад үнэт зүйл, сэтгэл хөдлөл ихээхэн нөлөөлдөг байна. Иймд оюутны суралцах хандлагыг дээшлүүлэхийн тулд оюутны үнэт зүйл болон харилцаанд анхаарлаа хандуулах ёстой (Beck D, Cowen C, 1996) ажээ. Мөн оюутан залуучуудад үнэт зүйлсийн баримжаалал төлөвшихөд их сургуулийн сургалтын систем, багш нарын заах арга барил, оюутны үйлчилгээний албаны үйл ажиллагаа шууд нөлөөлдөг болохыг (Duffy, R.D, Sedlocek. W.E, 2006) судлаачид тодорхойлжээ. Иймд оюутны суралцах хандлагыг дээшлүүлэхийн тулд оюутны үнэт зүйл болон харилцаанд анхаарлаа хандуулах ёстой ажээ. Залуучууд чухам юуг эрхэмлэж, юуг эс зөвшөөрч байгаагаар тухайн үндэстний соёлын хэв шинж, хөгжлийн онцлогийг тодорхойлж болно. Өрнөдийн судлаачдын үзсэнээр үндэстний үнэт зүйлд эрхэмлэж буй хүчин зүйлс, соёл, итгэл үнэмшлийн байдал шууд нөлөөлдөг байна. Үнэт зүйлийн судалгаанд түгээмэл хэрэглэж буй аргууд нь Шварц (Schwartz, Shalom H.; Rubel, Tammy, 2005), Хофштед (Hofstede, Geert, 2001), Инглехарт (Inglehart, Ronald and associates, 2007) нарын боловсруулсан аргачлалууд болно. Дурдсан судлаачдын хувьд хувь хүний болон нийгмийн үнэт зүйлсийг нийгэм, эдийн засаг, соёлын хүчин зүйлстэй холбон авч үзэж, тайлбарладаг болно.

Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн сүүлийн 30-аад жилд Монголчуудын нийгмийн харилцаанд олон тооны өөрчлөлт, хувьсал гарсан юм. Энэ нь юун түүрүүнд нийгмийн бүлгүүдийн үнэт зүйл, соёлын хөгжил, харилцаанд ихээхэн нөлөөлсөн. СУИС-аас 2019 онд санаачлан явуулсан “Монголчуудын үнэт зүйл” судалгааны үр дүнгээс үзэхэд (СУИС, 2019) судалгаанд оролцогчдын дийлэнх нь хувь хүний үнэт зүйлд гэр бүл, гэр бүлийн гишүүдийн эрүүл мэнд, эх орон, үндэстний тусгаар тогтнол, шударга ёс, хүнлэг ёс, нинжин сэтгэл, уламжлалт ёс заншил, эрдэм боловсролыг эрхэмлэн дээдэлдэг болох нь нотлогдсон. Тэрчлэн Монголчуудын эв эеийг эрхэмлэдэг, байгалийг хайрладаг, зочломтгой, төрөө дээдэлдэг, хүлээц тэвчээртэй, уужуу тайван, хөдөлмөрч, нэр төр хөөцөлддөггүй зэрэг ёс суртахууны эрхэм чанарууд алдагдаж буйг тус судалгаанд онцолсон юм. Хүн амьдралдаа чиг баримтлал болгодог үнэт зүйлгүй бол нийгэм хэмээх томоохон системийг нийтлэг зорилгоор удирдан чиглүүлэх боломжгүй болж, хүн бүр дур зоргоороо авирласан эмх цэгцгүй байдал үүснэ. Соёлын онолд тусгаснаар нийгмийн систем нь субъектийн хэрэгцээ, нийгэм соёлын орчны үнэт зүйл гэсэн дэд системийн харилцан уялдаанд үндэслэн бий болдог. Социологич Т.Парсонсын тэмдэглэснээр, өмнө дурдсан дэд системийн хооронд нэг талаас үнэт зүйл-хэм хэмжээний тогтсон агуулга, мөн чанарыг институц болгож, нийгмийн гишүүдэд хэвшүүлэн мөрдүүлэх, нөгөө талаас нийгмээр дагаж мөрдөж байгаа үнэт зүйл-хэм хэмжээг бие хүн өөртөө төлөвшүүлж, нийгэмших урвалж шинжтэй үйлдэл тасралтгүй явагдаж байдаг ажээ. Үүнд тулгуурлан авч үзэхэд өнөөгийн оюутнуудын амьдарч буй нийгмийн соёл, нийгмийн институц, хувь хүний амьдралын замнал туршлагаас эх сурвалжтай. Хүмүүс, хүн төрөлхтний түгээмэл хийгээд нийгмийн бүлгийн үнэт зүйлсийг амьдралынхаа явцад харилцан адилгүйгээр итгэл үнэмшлээ болгодог учир нэг хүнд хамгаас чухалд тооцогдох үнэт зүйл нөгөөд нь чухал бус байж болно.

Дэлхий нийтийг хамарсан даяаршил, мэдээлэл харилцаа холбооны технологийн хөгжил дэвшлийн нөлөөгөөр өнөөгийн оюутнуудын нийгмийн харилцаа бүхэлдээ хувьсан өөрчлөгдөж байна.

Одоогоос 10 гаруй жилийн өмнө ШУА-ийн Философи, Социологи, Эрхийн хүрээлэнгээс эрхлэн явуулсан судалгааны бүтээлд (ШУА, ФСЭХ, 2012) Монголын залуучуудын хувьд эцэг эх, эрүүл мэнд, эх орон, мэдлэг боловсрол, ажил мэргэжил, хүний эрх, ардчилал, эрх чөлөө нэн чухал болохыг судлан тодорхойлжээ.

Өнөөгийн Монголын нийгэм дэх оюутнуудын үнэт зүйлс бүрэлдэн төлөвшихөд нөлөөлж буй хүчин зүйлсийг макро түвшний буюу улс төрийн тогтолцоо, эдийн засгийн харилцаа, нийгмийн бүтэц ба өмч хөрөнгө, оюун санааны өөрчлөлт, даяаршил, гадаад ба дотоод шилжилт хөдөлгөөн, амьдралын хэв маяг, өв уламжлал зэрэгтэй, нөгөө талаас микро түвшний буюу хувь хүнээс өөрөөс хамаарах нас, хүйс боловсрол, орлого ба баялаг эзэмших байдал, гэр бүлийн харилцаа, шашин шүтлэг, оршин суугаа газар, хөдөлмөр эрхлэлт зэрэгтэй уялдуулан тайлбарлаж болох юм.

Хүснэгт-2. Үнэт зүйлс бүрэлдэн буй болоход нөлөөлөх хүчин зүйлс

Хувь хүний түвшний хүчин зүйлс	Нийгмийн түвшний хүчин зүйлс
Нас, хүйс	Амьдралын хэв маяг
Ажил мэргэжил	Улс төр
Хөдөлмөр	Мэдлэг боловсрол
Орлого ба баялаг	Нийгмийн бүтцийн өөрчлөлт
Гэр бүл	Хэвлэл мэдээлэл
Шашин шүтлэг	Оюун санааны өөрчлөлт
Нэр хүнд	Даяаршил

Залуучууд чухам юуг эрхэмлэж, юуг эс зөвшөөрч байгаагаар тухайн үндэстний соёлын хэв шинж, хөгжлийн онцлогийг тодорхойлж болно. Социалист аж төрөх ёс, нийтийн өмч, хамтын хөдөлмөр, нийгмийн сахилга дэг журмыг эрхэмлэж ирсэн социалист тогтолцооноос ардчилалд шилжсэнээр ардчилал, олон ургальч үзэл, хувь хүний эрх чөлөө, зах зээл, хувийн өмчийг эрхэмлэн дээдлэх болсон. Нөгөө талаас залуу нас бол амжилт бүтээл, алдаа оноо хосолсон хүний насны оргил үе билээ. Тиймээс ч залуу насанд оргилуун хүсэл, өөдрөг үзэл, шинэ санаа, эрч хүч, эр зориг, эрмэлзэх тэмүүлэл, хурц тод мэдрэмж, авьяас билгийн асар их нөөц бий (Х.Гүндсамбуу, С.Дашдаваа, 1998).

Залуу насанд хүн бие, сэтгэхүйн хөгжил болон нийгэмшилтийн хувьд бусдад хүлээн зөвшөөрөгдөж, аливаад бие даан оролцохын зэрэгцээ, эрх эдлэн үүрэг хүлээж нэг ёсондоо эрх зүйн чадамж бүрдэж эхэлдэг (М.Батбаатар, 2020). Үүний хамтаар боловсрох, мэргэжил эзэмших, гэр бүлийн амьдрал шинээр зохиох, эцэг эхээс өрх тусгаарлах, ажил хөдөлмөр эрхлэх зэрэг үүрэг хариуцлага хүлээхийн хэрээр олон асуудал тулгамдсан шинжтэй болж ирдэг.

Судалгаанд хамрагдсан залуучуудаас хөрөнгө чинээний хувьд өөрсдийгөө нийгмийн аль хэсэгт хамруулах талаар лавлахад 67.9% буюу таван залуу тутмын гурав нь өөрсдийгөө дундаж хэсэгт оруулж үзжээ. Харин дундаас дээгүүр хэсэгт 17.3%, дээд хэсэгт дөнгөж 3.2% нь өөрсдийгөө өөрсдийгөө оруулсан байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд таван оюутан тутмын нэг өөрсдийгөө аль ч хэсэгт оруулж мэдэхгүй байв. Оюутан залуусын орлогын хомсдол нь ихэнх тохиолдолд ажилгүйдлээс үүдэлтэй бөгөөд суралцаж буй тул цагаар ажиллаж өдөр тутмын санхүүгийн хэрэгцээгээ хангах боломж нөхцөл байдаггүйтэй энэ нь шууд холбоотой. Орлогын хомсдол бол оюутан залуучуудыг санхүүгийн хувьд бие даан амьдрах боломжгүй болгож, үүний улмаас эцэг эхтэй хамт урт хугацаанд амьдрах, гэр бүл төлөвлөлт хийгээд гэрлэх нас хойшлох, ганцаар амьдрахыг эрхэмлэх хандлага зонхилоход хүргэж байна. Сэтгэл хангалуун, сайн сайхан амьдрахын нэгэн үндэс бол орлого олох ажил, мэргэжилтэй байх явдал бөгөөд илүү сайн ажил эрхлэх, хөдөлмөрийн үнэлгээгээ нэмэгдүүлэх нэг гарц бол сурч боловсрох, мэргэжил эзэмших явдал хэмээн үзэж болно. Эдүгээ хөдөлмөр эрхлээгүй оюутнуудын дийлэнх нь сургууль завсардсан бус сурч байгаа залуучууд байна. Хөдөлмөрийн зах зээлд шинээр орж буй залуучууд бэлэн орон тоон дээр шууд ажиллах, эсвэл өөрөө бизнес эхлүүлэх боловсрол, мэдлэг, ур чадвар дутмаг байдаг. Үүнийг одоогийн сургалтын байгууллагуудын олгож буй мэдлэг, чадвар болон ажлын байранд шаардагдаж буй чадварын хоорондох ялгаа эрс тэс, тааруу байгаагаар тайлбарлаж болно. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас 15-29 насны залуучуудын амьдралын гол зорилготой холбоотой хэд хэдэн асуудлыг хөндөн судлахад ажил албан тушаалд хүрэхийг (17.0%), “мэргэшихийг” (19.8%), “аз жаргалтай байхыг” (18.9%) хамгийн чухал хэмээн үзжээ.

Оюутнуудын үнэт зүйлийг эх орон, эрхэмлэж явдаг зүйлс, мөнгө, зайлшгүй байвал зохих шинж чанар зэргээр үнэлүүлэхэд харилцан адилгүй хариулсан байна. Оюутнуудаас Монгол эх орноо чухам алианаар нь илүүтэй төсөөлдөг талаар асууж, хариултыг эрэмбэлж үзэхэд дараах онцлог харагдсан болно. Юуны өмнө оюутан залуучуудын хувьд Монголын түүх-24.1%, Уламжлал ёс заншил-22.5%, Газар нутаг-15.8%, Соёл-14.7% зэргээр эх орноо төсөөлж байгаа нь сайшаалтай хэрэг юм. Оюутан залуучуудын хувьд түүх уламжлал, ёс заншлаа мэдэх нь нэн чухал, түүх, газар нутаг, соёлоо мэдэх нь түүнээс ч дутуугүй чухал болохыг тухайн хариултаас харж болох юм. Үүний зэрэгцээ иргэд залуус-6.9%, түүхэн хүмүүс-5.6%, улс орны хөгжил цэцэглэлт-3.9%, урлаг-3.8% зэргийг эх орны талаарх төсөөлөл олгож байдаг чухал хүчин зүйл болохыг тэмдэглэсэн байна. Түүнчлэн шашин-1.7%, зэвсэгт хүчин-1.2% зэргээр эх орноо төсөөлж болох талаар дурдсан бөгөөд харьцангуй бага хувийг эзэлж байна.

Өнөөгийн оюутан залуучуудаас юуг зөвшөөрч, юуг эсэргүүцдэг, чухам юуг эрхэмлэж, юунд итгэдэг талаар асуухад харилцан адилгүй хариулт өгсөн байна. Оюутнуудын хариултаас үзэхэд цөөнгүй хувь нь гэр бүл (20.6%), мэдлэг боловсрол (19.2%), эрүүл мэнд (15.8%), эцэг эх (8.5%), хөдөлмөр (6.3%) зэрэг таван зүйлийг эрхэмлэж явдаг үнэт зүйлсээ гэж үзсэн байна. Үүнээс үзэхэд өнөөгийн оюутан залуучуудын хувьд гэр бүлийн үнэт зүйл(бүлгийн), дараа нь мэдлэг боловсрол(нийгмийн), тэгээд эрүүл мэнд (хувийн) зэрэг үнэт зүйлсийг илүүтэй эрхэмлэж явдаг ажээ. Үүний зэрэгцээ хүний эрх эрх чөлөө (6.0%), ардчилал (3.4%), хариуцлага (3.1%) зэрэг нийгмийн үнэт зүйлсийг эрхэмлэж явдаг хэсэг байна. Мөн эд хөрөнгө (2.3%), ажил мэргэжил (2.1%), нэр төр (2.0%) зэрэг хувийн зүйлийг бидний үнэт зүйлсэд чухал байр суурьтай гэж үзсэн байна.

Бидний судалсанаар, өнөөгийн оюутнуудын үнэт зүйлд байгаль орчин, тусгаар тогтнол, үндэсний уламжлал, хүнлэг ёс, энх тайван гэх мэт үнэт зүйл эд хөрөнгөнөөс хойгуур эрэмбэлэгдэж байгаа нь анхаарал татаж байна. Мөнгө бол орчин үеийн хэрэглээний чухал үүргийг гүйцэтгэдэг хэрэгсэл бөгөөд оюутнууд энэ талаар чухам ямар байр суурьтай байгааг таны бодлоор мөнгө бидний амьдралд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ? гэсэн асуултыг асуухад нийт дөрвөн оюутан тутмын нэг нь мөнгө бол ямар нэг байдлаар бүх юмны хэмжүүр-24.7% гэдэгтэй санал нийлжээ. Мөн судалгаанд хамрагдсан оюутнуудын 16.0% нь мөнгө бол амьдралыг хөдөлгөгч хүч гэж өргөн утгаар үзсэн байна. Эдгээр нь мөнгийг эрхэмлэх “хэт туйлширсан хэв маяг” бүхий үзэл бодол оюутнуудын дунд өндөр байгааг илтгэж байна. Тэрчлэн мөнгийг өөрийгөө хөгжүүлэх хэрэгсэл-14.0%, арилжааны хэрэгсэл-11.2%, хэрэглээ-9.3% зэргээр жинхэнэ мөн чанар, утга агуулга талаас тайлбарласан нь ч байна. Түүнчлэн мөнгөний хөрвөсөн үүрэг болох эрх мэдэлд хүрэх арга зам гэж 8.6% нь үзсэн бол амин чухал хэрэгцээ гэж 4.4% нь байр сууриа илэрхийлжээ. Хэдийгээр мөнгө бол арилжааны хэрэгсэл, хүний амьдралын хэрэгцээг хангагч нийгмийн өөрчлөлтөд ихээхэн нөлөөлдөг хүчин зүйл боловч мөнгийг хэт их шүтэх, материаллаг зүйлд дуртай байх нь “үнэ цэнтэй” болон “үнэтэй” зүйлээ ялгаж, салгаж чадахгүйд хүрч мэднэ.

Залуу хүнд зайлшгүй байх ёстой шинж чанаруудаас гадаад хэлтэй байх, эх оронч байх, хүссэнээ ямар нэг байдлаар биелүүлэх зэрэг шинж чанаруудыг чухал биш гэж үзэх хандлага бусад шинж чанаруудаас өндөр байлаа. Үнэт зүйлийн судалгаагаар оюутнууд нэгд хүмүүжил, ёс суртахуун (21.5%), хоёрт эрдэм боловсрол (18.6%), гуравт эх орон (10.8%), дөрөвт эрх чөлөөг (10.3%), тавд мөнгө (8.9%) эрхэмлэн дээдлэж явдгаа илэрхийлсэн /Хүснэгт-3-аас үзнэ үү/.

Хүснэгт-3. Та дор дурдсан үнэт зүйлсийн алийг нь илүүд үзэх вэ?

	Тоо	Хувь	Тохиолдлын хувь	I эрэмбэ	II эрэмбэ	III эрэмбэ
1.Хүмүүжил, ёс суртахуун	3644	21.5%	64.6%	39.4	19.3	5.8
2.Эрдэм боловсрол	3151	18.6%	55.9%	4.3	28.5	20.2
3.Эх орон	1822	10.8%	32.3%	7.2	19.2	23.1
4.Эрх чөлөө	1740	10.3%	30.9%	1.3	9.4	12.6
5. Мөнгө	1508	8.9%	26.7%	26.6	0.0	0.1
6.Эд хөрөнгө	1388	8.2%	24.6%	15.5	9.1	5.6
7.Гэр бүл	1342	7.9%	23.8%	0.2	3.0	4.0
8.Эрх мэдэл, албан тушаал	1016	6.0%	18.0%	5.1	7.3	5.9
9.Шударга ёс	924	5.5%	16.4%	0.2	3.5	20.6
10.Хангалуун амьдрал	254	1.5%	4.5%	0.1	0.4	1.9
11.Эрүүл мэнд	119	0.7%	2.1%	5.1	0.2	0.1
12.Шударга хөдөлмөр	6	0.0%	0.1%	39.4	0.0	5.6
Нийт хариулт	16914	100.0%	300%			

Хүснэгтэд үзүүлсэн, эрэмбэлсэн түвшнээс харахад хүмүүжил, ёс суртахуун ба шударга хөдөлмөр болон мөнгө, эд хөрөнгийг нэгд, эрдэм боловсрол, хүмүүжил ёс суртахуун, эх оронг хоёрт, эх орон, шударга ёс, эрдэм боловсролыг гуравт тавьж байгаа нь харагдаж байна.

ДҮГНЭЛТ

Хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэмд шилжин ороод 30 гаруй жил болж байгаа энэ хугацаанд нийгэм дэх насны бүлгүүд болох залуу, хижээл, ахмад үед харилцан адилгүй, өөр өөр итгэл үнэмшил бүрэлдэн тогтож Монголын нийгэмд үнэт зүйлийн цоо шинэ тогтолцоо үүсч байна. Иймд өнөөгийн нийгмийн нэн шинэ үе болох оюутнуудын үнэт зүйлийн онцлог, хөгжлийн хэрэгцээг энэхүү судалгааны үр дүнд тулгуурлан тодорхойлсон юм.

Оюутан залуус нийгмийн шинэчлэгч бүлэг болохын хувиар, нөгөө талаар Монголын нийгмийн амьдралыг өөр өнцгөөр “хардаг” бүлэг давхраа болохын хувьд өөрийн гэсэн итгэл үнэмшил, үнэлэмж, төсөөлөлтэй. Орчин цагийн Монголчууд эрх мэдэл, ая тав тух, цэнгэл жаргалыг нэгт тавьдаг болохыг олон судалгааны үр дүнгээс харж болох ч, энэ удаагийн судалгаанаас үзэхэд оюутнуудын үнэт зүйл харьцангуй өөр, олон янз төлөв байдлыг агуулж, басхүү төлөвшиж байна. Оюутан залуучуудын үнэт зүйлийг бүхэлд нь авч үзэхэд аюулгүй байх, эрүүл мэнд, нийгмийн дэг журам, гэр бүлийн амар тайван байдал, холбоо хамааралтай байх, үндэсний аюулгүй байдал, нийгмийн шударга ёс, энх тайван, байгаль орчноо хамгаалах зэрэг универсал буюу түгээмэл үнэт зүйлийг нэн тэргүүнд эрхэмлэн дээдэлж байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд оюутнуудын цөөнгүй хувь нь гэр бүл (20.6%), мэдлэг боловсрол (19.2%), эрүүл мэнд (15.8%), эцэг эх (8.5%), хөдөлмөр (6.3%) зэрэг таван зүйлийг эрхэмлэж явдаг үнэт зүйлсээ гэж үзсэн байна. Үүнээс үзэхэд өнөөгийн оюутан залуучуудын хувьд гэр бүлийн үнэт зүйл(бүлгийн), дараа нь мэдлэг боловсрол (нийгмийн), тэгээд эрүүл мэнд(хувийн) зэрэг үнэт зүйлсийг илүүтэй эрхэмлэж явдаг гэж дүгнэж болно.

Монгол хүний шударга зан, чин үнэнч нөхөрлөл, үнэнч байдал, хариуцлагатай байдал, хайр халамж, уучлах сэтгэл, тусч байдал, оюун санаа, уужуу ухааныг эрхэмлэн үздэг бол оюутнуудын хувьд эрдэм мэдлэг, эх орон, эцэг эх зэрэг зүйлийг эрхэмлэж явдаг болохоо дурдсан байна.

Мөн өгөөмөр байх, нийцтэй байх хамтач байдлын үнэт зүйл оюутнуудын хувьд илүү түгээмэл ажиглагдаж байна. Энэ нь ойр дотны хүмүүсээ хайрлах, бусдыг гомдоохгүй, санал, үзэл бодлыг нь хүндэтгэх байдлаар илэрдэг. Тэрчлэн оюутнуудын хувьд эрх мэдэл-амжилт зэрэг нь дараагийн чухал үнэт зүйлсэд тооцогдож байна. Нийгмийн байр суурь, удирдах эрх мэдэл, нэр нөлөөтэй байх, нийгэмд танигдах, эд баялаг, амжилт, ухаалаг байдал, чадвар чадавх зэрэг нь хувь хүний байр суурийг бэхжүүлэхэд чиглэж байдгаараа онцлог юм. Ялангуяа оюутнуудын хувьд энэхүү үнэт зүйл нэн чухалд тооцогдож байна.

Залуучуудын дундах өвөрмөц бүлэг болохын хувьд өнөөгийн Монголын оюутан залуус хараат бус тайван байдалд амьдрах, сайн эцэг эх болох, амжилттай ажил хөдөлмөр эрхлэх тухай ирээдүйн төсөөлөл нь тэдгээрийн үнэт зүйлийн баримжаалалтай уялдаатай байгаа болно.

The Formation and Characteristics of University Students' Values in Mongolia

Batbaatar Monkhooroi 

Associate Professor, Department of Sociology and Social Work, National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

Summary: This article examines the current situation of Mongolian university students the country's foundational demographic group by comparing their challenges, value formation, and characteristics. With the transition from a socialist system, which emphasized collective living, public ownership, cooperative labor, and social discipline, to a democratic and market-based society, people's values and priorities have shifted significantly. In this open, market-oriented society that followed socialism, the values and principles of young people have undergone considerable changes. A study on students' values revealed that the most important aspects they prioritize are: 1. Upbringing and morality (21.5%) 2. Education and knowledge (18.6%) 3. Patriotism (10.8%) 4. Freedom (10.3%) 5. Money (8.9%).

This article presents the key findings of a study that surveyed 5,638 university students from various regions of Mongolia who are currently studying in the capital city, using a random sampling method.

Keywords: Socio-demographic group, lifestyle, problem, values, order

Ном зүй

- Beck D, Cowen C. (1996). *Spiral dynamics: Mastering values, leadership, and change*. NY: Cambridge; MA; Balckwell.
- Duffy, R.D, Sedlocek. W.E. (2006). Correlates of Open and closed values systems among University students. *NASPA*, 1-12. <https://doi.org/10.2202/1949-6605.1720>
- Hofstede, Geert. (2001). *Culture's Consequences, (Second Edition): Comparing Values, Behaviors, Institutions and Organizations Across Nations*. Thousand Oaks CA: Sage Publications.
- Inglehart, Ronald and associates. (2007). *World Values Survey: The World's Most Comprehensive Investigation of Political and Sociocultural Change*. <http://www.worldvaluessurvey.org>.
- Schwartz, Shalom H.; Rubel, Tammy. (2005). "Sex differences in value priorities: Cross-cultural and multimethod studies". *Journal of Personality and Social Psychology*. 89 (6): 1010–1028. <https://doi.org/10.1037/0022-3514.89.6.1010>
- Shatz, Howard J., Louay Constant, Francisco Perez-Arce, Eric Robinson, Robin L. Beckman, Haijing . (2015). *Improving the Mongolian Labor* . Ulaanbaatar: Rand Corporation.
- Skelton.A. (1997). *Studying hidden curriculum: Developing a Perspective in the Light of Postmodern Insights*. *Curriculum studies*. NY. <https://doi.org/10.1080/14681369700200007>
- Sukhee.A. (2023). Exploring the Relationship Between Personal Values and Professional Attitude of Journalism Students. *Lavai, International Journal of Education, Volume 19, No 28*, 2-15. <https://doi.org/10.5564/lavai.v19i28.2799>
- UN. (2024, 12 13). <http://www.un.org/en/events/youthday/sg.shtml>. Улаанбаатар, Монгол, Монгол.
- Гаврилюк.В, Трикоз.Н. (2002). Динамика ценностных ориентаций в период социальной трансформации. *СоцИС №2*, 96-105. <https://studfile.net/preview/460521/>
- М.Батбаатар. (2020). *Залуучуудын хөгжлийн төвийн жишиг үйлчилгээг боловсруулах нь*. Улаанбаатар: ХНХЯ. https://mlsp.gov.mn/uploads/files/45Zaluuchuudiiin_hugjliig_demjih_niitleg_uilchilgeenii_standart_bolovsruulah.pdf
- МЗХ, Полиси төв. (2003). *Монголын залуучуудын суурь хэрэгцээ*. Улаанбаатар: МЗХ.
- МУЗГ. (1998). *Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого*. Улаанбаатар: МУЗГ. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=6278>
- МУЗГ. (2006). *Өсвөр үе, залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр*. Улаанбаатар: МУЗГ.
- Социологийн Боловсрол төв. (2023). *Оюутан залуучуудын үнэт зүйл, хөгжлийн хэрэгцээг тодорхойлох суурь судалгаа*. Улаанбаатар: СБТ.
- СУИС. (2019). *Монголчуудын үнэт зүйл. Судалгааны тайлан*. Улаанбаатар: СУИС.

УИХ. (2017). *Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль*. Улаанбаатар: УИХ.
<https://legalinfo.mn/mn/detail/12658>

Үндэсний статистикийн хороо. (2019). *Боловсролын салбарын суурь мэдээллийн танилцуулга*.
Улаанбаатар: ҮСХ.

Үндэсний статистикийн хороо. (2024). *Статистикийн мэдээллийн нэгдсэн сан*. Улаанбаатар:
ҮСХ. <https://www.1212.mn/>

Х.Гүндсамбуу, С.Дашдаваа. (1998). *XX зууны босгон дахь Монголын залуучууд*. Улаанбаатар:
ННХ.

ШУА, ФСЭХ. (2012). *Монголын залуучуудын нийгмийн дүр төрх*. Улаанбаатар: ШУА.

ШУТС-ийн төслийн тайлан. (2018). *Монголын хүүхэд, залуусын хөгжлийн шалгуур үзүүлэлтийг
тодорхойлох технологийг сургалтын практикт нэвтрүүлэх нь*. Улаанбаатар: ШУТС.
https://api.mnier.mn/uploads/4270f_tailan_2018_hvreelen_4_9_1_a6b5db942c.pdf